



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

Байгууллагын нууцыг тогтоох тухай

Байгууллагын нууцын тухай хуулийг үндэслэн ТУШААХ НЬ:

- Нэг. Байгууллагын нууцад хамаарах материалуудыг хавсралтаар баталсугай.
- Хоёр. Хавсралтаар баталсан байгууллагын нууцад хамаарах материалуудыг ажиллаж байх хугацаандаа болон хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон үед бусдад мэдээлэлж, задруулахгүй байхыг нийт эмч, эрүүл мэндийн ажилтнуудад үүрэг болгосугай.
- Гурав. Байгууллагын нууцыг задруулсан эмч, эрүүл мэндийн ажилтныг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль, тогтоомжинд заасны дагуу арга хэмжээ авахыг нийт эмч, эрүүл мэндийн ажилтнуудад анхааруулсугай.
- Дөрөв. Удирдлагын заалтын дагуу албан хэрэгцээнд хавсралтаар баталсан нууц материалуудыг ашиглахыг холбогдох албан тушаалтнуудад зөвшөөрсүгэй.
- Тав. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/, Нууцын ажилтан, бичгийн хэргийн ажилтан /Л.Пагмажав/ нарт даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

СЭМҮТөрийн Ерөнхий захирлын
2012 оны 11 сарын 27-ны өдрийн
261 тоот тушаалын 3 хавсралт

Байгууллагын нууцад хамаарах материалууд

1. Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө
2. Стратеги төлөвлөгөө
3. Мэргэжлийн хамтын ажиллагаатай байгууллагуудтай байгуулсан гэрээ
4. Санхүү, тайлантай холбоотой бүх үзүүлэлтүүд:
 - Харилцах дансны хуулга, түүний үндсэн баримтууд үлдэгдэл
 - Кассын баримтууд түүний үлдэгдэл, кассын тайлан
 - Ажилтнуудын нэрийн дансны жагсаалт
 - Ажилтнуудын цалин хөлс тогтоосон тушаал, шийдвэрүүд
 - Ажилтнуудын цалингийн хүснэгт, цалингийн холбогдолтой баримтууд
 - Хөрөнгийн тооллогын бүртгэл
 - Санхүүгийн тайлан бланс, төсвийн төлөвлөгөө, тооцоо түүнд холбогдох баримтууд
 - Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бусад баримтууд
5. Хүний нөөцтэй холбоотой материалууд:
 - Ажилтнуудын гэрийн хаяг
 - Хувийн хэрэгцээнд ашигладаг гар утасны дугаар
 - Хөдөлмөрийн гэрээ
 - Хувь хүний нууцтай холбоотой бусад мэдээллүүд
6. Эмчлүүлэгчтэй холбоотой материалууд:
 - Эмчлүүлэгчийн өвчний түүх
 - Хяналтанд байдаг эмчлүүлэгчийн амбулаторийн карт
 - Шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагааны дүгнэлт
 - Эмгэг сэтгэл судлалын шинжилгээний дүгнэлт
 - Эмчлүүлэгчтэй холбоотой бусад мэдээллүүд